



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 02 өдөр

Дугаар A/547

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.д, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 459 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БНСУ-ын зөвлөх үйлчилгээний компани Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотын дулааны станц, дулааны төв шугам сүлжээ барих төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах явцад холбогдох мэдээллээр шуурхай хангах, орон нутгаас хамааралтай тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэн ажиллах 2 дугаар контурын шугамын трассыг тодорхойлж, зургийн даалгаврыг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Гүнсэнхорол –Аймгийн Засаг даргын дэргэдэх
Газрын харилцаа, барилга, байгуулалтын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Г.Түвшинтөр - Аймгийн ерөнхий архитектор

Гишүүд: Д.Должинсүрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

А.Энхцэцэг -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын хэлтсийн дарга

Л. Дүүмаа -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа
барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

С.Зоригтбаатар -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын
харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодезын инженер

Д.Дагвадорж -Онги-Ус суваг ОНӨААТҮГазрын ерөнхий инженер
Д.Цэцэгмаа -Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны

гишүүн

Т.Сономцэрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн
хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

О.Бат-Эрдэнэ -“Эрдэнэт, Булган цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-
ний ахлах инженер

Ц. Чулуунцэцэг “Мэдээлэл холбооны сүлжээ” –ний кабель
шугамын инженер

2. Зургийн даалгаврыг боловсруулах ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 10-
ны дотор хийж гүйцэтгэн танилцуулахыг ажлын хэсэг (Ч.Гүнсэнхорол)-д
даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД 011100985